

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-4

1. Дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудал 3-4

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
07 дугаар сарын 09-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 31 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 54.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 10 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Ганбаатар;

Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, О.Батнайрамдал, П.Батчимэг, Ш.Бямбасүрэн, Б.Жавхлан, Ч.Лодойсамбуу, Б.Пунсалмаа, Р.Сэддорж, О.Цогтгэрэл, М.Энхцэцэг.

Нэг.Дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Дэд хороодын бүрэлдэхүүний тухай асуудлыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг, М.Мандхай, Б.Тулга нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Ж.Бат-Эрдэнэ: Аялал жуулчлалын хөгжлийн, Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн, Инновац, цахим бодлогын хөгжлийн, Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороодын бүрэлдэхүүнийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	7
Бүгд:	20

65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 13 минут үргэлжилж, ирвэл зохих 31 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 61.5 хувийн ирцтэйгээр 12 цаг 23 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Лхагва гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим
12 цаг 10 минут.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг та бүхэндээ танилцуулъя. Хүрэлцэн ирсэн гишүүдийг танилцуулъя. Чинбаатарын Анар гишүүн ирсэн байна. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн ирсэн. Мэндбаярын Мандхай гишүүн ирсэн. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн ирсэн. Болдын Уянга гишүүн ирсэн. Цэндийн Баатархүү гишүүн ирсэн. Ринчиндоржийн Батболд гишүүн ирсэн. Пүрэвжавын Ганзориг гишүүн ирсэн. Бадрахын Найдалаа гишүүн ирсэн. Буяагийн Тулга гишүүн ирсэн. Саруулсайханы Цэнгүүн гишүүн ирсэн. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн ирсэн. Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн ирсэн. Ганзоригийн Лувсанжамц гишүүн ирсэн. Ганбатын Очирбат гишүүн ирсэн. Агваанлуvsангийн Ундраа нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

1.Дэд хорооных бүрэлдэхүүний тухай асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүд байна уу. Алга байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг хэлэлцэнэ.

Дэд хорооны бүрэлдэхүүнийг Улсын Их Хурал дахь олонх цөөнхийн төлөөллийг харгалзан байгуулна. Дэд хороодын бүрэлдэхүүний талаар нам, эвслийн бүлгүүдийн саналыг уншиж танилцуулна. Дэд хорооны бүрэлдэхүүнийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Аялал жуулчлалын хөгжлийн дэд хороо:

Нацагдоржийн Батсүмбэрэл, Буяагийн Тулга, Мөнхчулууны Энхцэцэг, Ганзоригийн Лувсанжамц, Ренчиндоржийн Батболд, Шинэбаярын Бямбасүрэн, Эрдэнэбилэгийн Одбаяр,

Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо:

Отгоншарын Батнайрамдал, Жамбалын Ганбаатар, Жуковын Алдаржавхлан, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Пүрэвийн Батчимэг, Ренчинбямбын Сэддорж, Цэндийн Баатархүү.

Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хороо:

Чинбаатарын Анар, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Жадамбын Бат-Эрдэнэ, Буяагийн Тулга, Хүрэлбаатарын Булгантуяа, Батбаярын Жаргалан, Ринчиндоржийн Батболд, Цэндийн Баатархүү, Пүрэвжавын Ганзориг.

Тогтвортой хөгжлийн зорилтын дэд хороо:

Болдын Уянга, Ганзоригийн Лувсанжамц, Мэндбаярын Мандхай, Батжаргалын Заяабал, Бадрахын Найдалаа, Агваанлуvsсангийн Ундраа, Саруулсайханы Цэнгүүн, Бадамдоржийн Пунсалмаа.

Та бүхэнд дэд хороодын нэрсийг танилцууллаа. Дэд хороодын нэрстэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу. Нэрс авъя. Ганзориг гишүүнээр тасаллаа. Ганзориг гишүүн.

П.Ганзориг: Дэд хороодын хуваарилалт дээр намайг Инновац, цахим хөгжлийн дэд хороо дээр оруулчихсан байх шиг байна. Тэгээд өнгөрсөн жилийн хугацаанд Аж үйлдвэрийн байнгын хороо дээр ажиллаж байхдаа Бадамсүрэн гишүүн бид нар бас Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр ажлын хэсэг байгуулаад, тодорхой бас дүгнэлт, санал гаргаад ажиллаад явж байгаа. Тэгээд цаашдаа жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлд ажиллаж бас үргэлжлүүлээд ажиллах ийм хүсэлтэй байгаа болохоор Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих дэд хороо руу оруулж өгөх ийм саналыг, хүсэлтийг тавьж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Батчимэг гишүүн тийм санал тавьсан юм байгаа юм уу. Групп дээр бичсэн байна. Тэгвэл ер нь бол солилцоод орчихсон нь дээр л дээ. Бид нар бас харьцаагаа харсан юм байгаа юм. Тэгвэл Пүрэвжавын Ганзориг гишүүнийг Жижиг, дунд үйлдвэрлэлийн дэд хороо руу шилжүүлээд, Батчимэг гишүүнийхээ юун дээр байгаа юу. Пүрэвийн Батчимэг гишүүн Жижиг, дунд үйлдвэрлэл хөгжил дээр байж байна. Мандхай гишүүний микрофоныг нээе.

М.Мандхай: Дарга аа, нөгөө Батчимэг гишүүн Тогтвортой хөгжил рүү орох сонирхолтой байгаа. Би болохоор Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих рүү орох сонирхолтой байгаа. Тэгээд тийшээгээ би Тогтвортой хөгжлөөс Жижиг, дунд үйлдвэрлэл рүү орж болох болов уу. Бид 2-ыг солиод өгөөч ээ. Батчимэг гишүүн Тогтвортой хөгжил рүү ороод, Батчимэг гишүүн одоо жижиг дунд дээр байгаа. Тэгэхээр би жижиг дунд руу ороод солигдох хүсэлтэй байна.

Ж.Бат-Эрдэнэ: Ганзориг гишүүний микрофоныг нээе.

П.Ганзориг: Энэ дэд хороодын бүрэлдэхүүний асуудал дээр сая бас миний бие санал гаргасан бас зарим гишүүд санал гаргаж байна. Тэгэхээр одоо энэ орж ирсэн саналаараа батлаад, тэгээд намрын чуулганаар хэдүүлээ намын бүлэг, зөвлөлүүдээрээ ярьж байгаад хуваарилалтаа дахин хийе гэсэн саналтай байна.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ зүйтэй санал гарч байх шиг байна. Намрын чуулган эхлэх үед бүлгүүд хоорондоо бас ярилцах хэрэгтэй байна. Тийм үү. Бүлэг дотроо ярилцаад, тэгж байж хоорондоо бас асуудлаа шийдээд, тэгээд Байнгын хороо руугаа орж ирье. Дараа нь Тулга гишүүн.

Б.Тулга: Байнгын хороодын гишүүдийн энэ өдрийн амгаланг эрье. Зүгээр энэ дэд хороо шинээр байгуулагдаж байгаатай холбоотой манайхан тайлбарлаж өгөөч. Дэд хороо яг ямар үүрэгтэй байх билээ. Яаж ажиллах юм бэ Байнгын хороотойгоо. Энэ талаар манай Байнгын хорооноос тайлбар өгөөч.

Ж.Бат-Эрдэнэ: Ер нь бол эрхлэх асуудлынхаа хүрээнд бүх асуудлуудыг дэд хороон дээрээ л шийднэ. Тэгээд дэд хорооноос саналаа Байнгын хороо руу орж ирэх юм шүү. Ер нь бол тодорхой асуудал Байнгын хорооноосоо цохогдож, дэд хороо дээрээ очоод, дэд хороо дээрээ тодорхой яг заасан асуудлынхаа хүрээнд, тогтсон асуудлынхаа хүрээнд хуулийн хүрээнд бүх асуудлуудаа шийдээд, тэгээд асуудлаа Байнгын хороондоо оруулж асуудлаа шийддэг ийм зарчимтай байх юм шүү. Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйл. Дэд хороо.

27.1.Байнгын хороонд хорооны харьяанд түүний эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцах үүрэг бүхий дэд хороо байгуулж болно. Дэд хороо нь эрхлэх асуудлынхаа хүрээнд судалгаа хийх, холбогдох мэдээлэл авах, зохих албан тушаалтан, иргэн, албан байгууллагаас тайлбар авах, ажлын хэсэг байгуулах, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах гэж байгаа шүү. Улсын Их Хурлын төсөл боловсруулах санал, дүгнэлт гаргаж, түүнийгээ харьяалагдах Байнгын хороонд шаардлагатай бол Байнгын хороогоор уламжлан, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, эрхэлсэн асуудлаараа тогтоол гаргах эрхтэй гэж байгаа юм. Тогтоол гаргах эрхтэй.

Өөрөөр хэлбэл тодорхой эрх эрхэлсэн асуудлаараа Улсын Их Хурал чуулганаар хэлэлцүүлэх тогтоолын төслийг Байнгын хороогоороо оролцуулаад, Байнгын хороогоороо дамжуулаад хэлэлцүүлээд, Улсын Их Хуралд өргөн барих, чуулганаар хэлэлцэх ийм боломж бололцоо байгаа.

Тэгэхээр нэлээн өргөн хүрээнд ажиллах бололцоотой. Эрхэлсэн асуудлынхаа хүрээнд тэгж байгаа шүү. Гишүүд асуулт асууж, хариулт авч үг хэлж дууслаа. Санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Саналын томьёолол.

Аялал жуулчлалын хөгжлийн, Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн, Инновац, цахим бодлогын хөгжлийн, Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороодыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Бүрэлдэхүүнийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 20 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 65 хувиар санал дэмжигдлээ.

Энэ доторх гишүүдийгээ түрүүн дурдчихсан. Тэгээд дурдсан тул яг энэ хэмжээндээ батлагдлаа гэж тооцсон. Тийм үү. Ингээд санал хураалт явагдаж дууслаа. Дэд хороодын бүрэлдэхүүнд нэр дэвшүүлсэн талаарх Байнгын хорооноос гаргах санал дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ. Соронзонболд гишүүн танилцуулъя. Ингээд хуралдаан дууссан тул хурал хаасныг мэдэгдье.

12.23 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ